



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

**ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД**

2024.04.23 № А-1/1657
танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Тус газраас зарласан БШУЯ/20240101069/02/01 урилгын дугаартай XIII.1.1.320 "Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Төв, Зуунмод сум, 5 дугаар сургууль/" төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгын хариуг хүргүүлж байна. Үүнд:

№	Тодруулга	Тодруулгын хариу
1	ТШӨХ-д батлагдсан төсөвт өртгийн тодорхой хувиар хангах шаардлагууд байгаа ба уг батлагдсан төсөвт өртгийг улсын төсөвт батлагдсан нийт төсөвт өртгийн дүн эсвэл зураг төсвийн магадлалаар баталгаажсан төсөвт өртөг хоёрын аль дүнгээр тооцож тендерт бэлтгэх.	Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын дагуу батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.8.4-д зааснаар "Гүйцэтгэлийн санхүүжилтийг хуулиар батлагдсан төсөвт өртөг, магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан төсөвт багтаан гэрээнд үндэслэн тухайн төсөл, арга хэмжээний зураг төсөл, төсөв, холбогдох норм, нормативын баримт бичгийг үндэслэн барилга угсралтын гэрээнд тусгасан үе шатны ажил тус бүрээр гаргаж, магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй тулган шалгаж, хянан баталгаажуулна" гэж заасны дагуу магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан төсөвт өртгөөс хэтрүүлэхгүй тооцож ирүүлнэ.
2	ТШӨХ-ийн ТШЗ 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагын БА-2.1 болон БА-7.1 заалтуудыг уг заалтуудын ахисан түвшний заалт болох БА-3.1 болон БА-8.1 заалтуудаар шаардлагыг хангаж болох эсэх	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15.1-д "гэрээний үүрэг гүйцэтгэхэд сонирхогч этгээд болон оролцогчид тавигдах зайлшгүй шаардлагад үндэслэсэн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана" гэж заасан. Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны "Аргачлал батлах тухай" 33 дугаар тушаал, 2021 оны 147 дугаар тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам"-ын дагуу зарласан тусгай зөвшөөрлийг дүйцүүлж зээх боломжтой.

ДАРГА

Ц.БАТЗУЛ